



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/74/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Гэрээт ажилтан: Ц.Лүндэгмаа

Утас: 99026829

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.ХОРОЛСҮРЭН ТАНАА

2021.07.24 № 16/100
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

1. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын төсвөөс зориулалт бусаар Сайншанд сумын 4-р багт 6,5 сая төгрөгийн сагсан бөмбөгийн талбай байгуулсан байна.
2. Хурлын төлөөлөгч нарт 2131,2 мянган төгрөгийн "Сайншанд сумын ИТХ" гэсэн бичиг бүхий тэмдэглэлийн дэвтэр, бал, хавтас, флаш олгосон,
3. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас Увс аймгийн ИТХ-ын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлаар явахад 4.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан төсвийн эх үүсвэрийн ангилал, 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,308,826.00	5,432,288.54
33	АВЛАГА	-	2,014,462.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,614,462.54
335	Бусад авлага	-	400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,308,826.00	3,417,826.00
354	Хангамжийн материал	3,308,826.00	3,417,826.00
35410	Бичиг хэргийн материал	245,900.00	245,900.00
35420	Аж ахуйн материал	3,062,926.00	3,171,926.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,070,389.92	5,038,597.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,070,389.92	5,038,597.36
392	Биет хөрөнгө	8,070,389.92	4,686,597.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,430,000.00	98,430,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,483,166.61)	(98,430,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,500,911.00	10,500,911.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,353,116.62)	(9,274,903.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,294,231.50	20,694,231.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,590,691.58)	(19,172,530.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(777,777.77)	(2,111,111.09)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	-	352,000.00
39301	Програм хангамж	-	352,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,379,215.92	10,470,885.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	657,001.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	657,001.00	-
413	Өглөг	657,001.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	657,001.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,722,214.92	10,470,885.90
51	Засгийн газрын хувь оролцоо	10,722,214.92	10,470,885.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,768,306.99	11,768,306.99
51101	Өмч: - төрийн	11,768,306.99	11,768,306.99
512	Хуримтлагдсан үр дүн	(1,134,390.87)	(1,385,719.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,134,390.87)	(1,134,390.87)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(251,329.02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,298.80	88,298.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,379,215.92	10,470,885.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	128,968,200.00	97,487,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	352,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	352,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	352,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	352,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	128,968,200.00	97,135,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,768,200.00	96,735,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,768,200.00	96,735,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	129,626,444.51	97,739,029.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	129,626,444.51	97,739,029.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,498,051.53	96,801,215.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,653,975.01	61,365,078.87
210101	Үндсэн цалин	60,653,975.01	61,365,078.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,396,126.51	9,021,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,713,674.62	6,135,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	787,152.89	721,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	273,713.00	577,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	56,506.00	143,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	565,080.00	1,443,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,850,694.50	9,737,956.50
210401	Бичиг хэрэг	2,298,848.00	1,736,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,528,260.00	7,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	487,586.50	497,706.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	72,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,536,000.00	231,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	-
210604	Урсгал засвар	500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	653,000.00	109,200.00
210702	Дотоод албан томилолт	653,000.00	109,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,274,710.00	8,412,193.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,052,790.00	8,211,693.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	110,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,169,545.51	8,155,587.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	800,000.00	4,371,795.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,369,545.51	3,783,792.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,128,392.98	937,813.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,128,392.98	937,813.09
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,128,392.98	537,813.09
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(658,244.51)	(251,329.02)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(658,244.51)	(251,329.02)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	129,178,200.00	97,135,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	129,178,200.00	97,135,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	410,000.00	400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	410,000.00	400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,768,200.00	96,735,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,768,200.00	96,735,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	124,760,300.00	96,735,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,760,300.00	96,735,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,631,907.02	95,797,886.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,996,974.01	63,636,542.41
210101	Үндсэн цалин	59,996,974.01	63,636,542.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,396,126.51	9,021,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,173,727.00	6,135,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	444,000.00	721,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	555,600.00	577,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	110,400.00	143,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,112,399.51	1,443,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,284,386.50	5,226,156.50
210401	Бичиг хэрэг	1,097,250.00	1,099,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,550.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	487,586.50	497,706.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	72,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	557,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	-
210604	Урсгал засвар	500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	653,000.00	109,200.00
210702	Дотоод албан томилолт	653,000.00	109,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,001,420.00	9,005,493.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,774,500.00	8,636,993.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	110,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,920.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	8,799,295.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	8,799,295.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,128,392.98	937,813.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,128,392.98	937,813.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,128,392.98	537,813.09
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,417,900.00	400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,417,900.00	400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,417,900.00	400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,417,900.00	400,000.00
223001	Бусад хөрөнгө	4,417,900.00	400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,417,900.00)	(400,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(476,146.36)	11,380,459.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(476,146.36)	11,380,459.43
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(658,244.51)	(658,244.51)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(1,134,390.87)	10,722,214.92
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(1,134,390.87)	10,722,214.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(1,134,390.87)	10,722,214.92
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(251,329.02)	(251,329.02)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(1,385,719.89)	10,470,885.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,020,200.00	96,735,700.00	11,284,500.00	89.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,020,200.00	96,735,700.00	11,284,500.00	89.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,020,200.00	96,197,886.91	11,822,313.09	89.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,659,400.00	63,636,542.41	1,022,857.59	98.42
210101	Үндсэн цалин	64,659,400.00	63,636,542.41	1,022,857.59	98.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,021,200.00	9,021,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	6,135,500.00	6,135,500.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	721,100.00	721,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	577,400.00	577,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	143,700.00	143,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,443,500.00	1,443,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,422,000.00	5,226,156.50	195,843.50	96.39
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,099,400.00	600.00	99.95
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00	497,706.50	52,293.50	90.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	72,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	557,050.00	142,950.00	79.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	400,000.00	5,600,000.00	6.67

210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	-	4,000,000.00	-
210602	Тавилга	2,000,000.00	400,000.00	1,600,000.00	20.00
2107	Томилолт, зочны зардал	109,200.00	109,200.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	109,200.00	109,200.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,008,400.00	9,005,493.00	5,002,907.00	64.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,585,400.00	8,636,993.00	4,948,407.00	63.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	168,000.00	168,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	90,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	110,500.00	14,500.00	88.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	-	40,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,800,000.00	8,799,295.00	705.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,800,000.00	8,799,295.00	705.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	537,813.09	(537,813.09)	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	537,813.09	(537,813.09)	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		537,813.09	(537,813.09)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,020,200.00	96,735,700.00	11,284,500.00	89.55
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,020,200.00	96,735,700.00	11,284,500.00	89.55
132001	Орон нутгийн төсвөөс	108,020,200.00	96,735,700.00	11,284,500.00	89.55

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /				
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	400,000.00	(400,000.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	400,000.00	(400,000.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	400,000.00	(400,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	400,000.00	(400,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	400,000.00	(400,000.00)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайншанд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ИТХ-ын дарга Х.Хоролсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 15–ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлж, хөгжүүлэх гэсэн эрхэм зорилго дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

- Үйл ажиллагааны чиглэл нь: Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайншанд сумын ИТХ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 44,339.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 443.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 97,739.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 977.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 908.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	2,014.5	2,014.5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	3,308.8	3,417.8	109.0
Үндсэн хөрөнгө	8,070.4	5,038.6	-3,031.8
Нийт хөрөнгө	11,379.2	10,470.9	-908.3
Өр төлбөр	657.0	0	-657.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,722.2	10,470.9	-251.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,379.2	10,470.9	-908.3

Авлага дансны үлдэгдэл 2,014.5 мянган төгрөг болж 2014.5 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан ХХОАТ-ыг 1614.4 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл төвлөрүүлсэн 400.0 мянган төгрөгийг авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,417.8 мянган төгрөг болж 109.0 мянган төгрөгөөр өссөн ААМ-ын үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,038.6 мянган төгрөг болж 3,031.8 мянган төгрөгөөр буурсан нь 752.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 3,783.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь 752.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь урсгал төсвийн худалдан авалтаар 400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 352.0 мянган төгрөгийн программ хангамжийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 болж 657.0 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,470.9 мянган төгрөг болж 251.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

ИТХ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 31,480.5 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого буурсан нь өмнөх онд тайлант оноос өндөр төсөв баталсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 31,887.3 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн буурсан байна. Төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр үндэслэж бодитой тооцоогүйгээс өмнөх оны зардлын төсөв өндөр байсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 128,699.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 128,699.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн дүнгээр сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор ИТХ-ын төсвийг баталсан ба 2020 оны 12 сарын 02/04 дүгээр тогтоолоор 108,020.2 мянган төгрөг болгон анхны баталсан төсвийг 20,679.2 мянган төгрөгөөр бууруулж өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 108,020.2 мянган төгрөгийн төсөв баталж төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 96,735.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 96,197.9 мянган төгрөгийг зарцуулж 537.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96,197.9 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс 11,284.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас шагналын 400.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, үлдэгдэл 400.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 76.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 432.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмж 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	76.8	1	76.8			
Албан шаардлага	2	432.3	2	432.3			
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	4	509.1	4	509.1			

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,500.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 6,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6,500.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

1. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын төсвөөс зориулалт бусаар Сайншанд сумын 4-р багт 6,5 сая төгрөгийн сагсан бөмбөгийн талбай байгуулсан нь нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 заалт, 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан төсвийн эх үүсвэрийн ангилал, 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх нэг албан шаардлага бичлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

ИТХ нь 2020 оны 6 сард нэг удаа эргэлтийн хөрөнгийн тооллого хийсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу эргэлтийн хөрөнгийг жилд 2 удаа, үндсэн хөрөнгийг жилийн эцэст тоолсон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Шатахууны тайланд шатахууны толон орлогодож, зарлагадсан ба бензин, дизелийн түлш, тос масло ямар хэмжээгээр авсан нь тодорхойгүй байгаа нь анхаарал татахуйц байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сайншанд сумын ИТХ-ын 2019.12.11-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор сумын ИТХ-ын төсвийг 128,7 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2020.12.16-ны өдрийн 02/04 дүгээр тогтоолоор 108,0 сая төгрөг болгон 20.7 сая төгрөгөөр бууруулж төсөв баталсан байна. Тайлант онд төсвийн гүйцэтгэлээр 96.7 сая төгрөгийн санхүүжилт буюу 11.3 сая төгрөгийн дутуу санхүүжилт авч зарцуулсан ба 537.8 мянган төгрөгийг жилийн эцэст буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх, 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг тус тус зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулах, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд заасан төсөв батлахтай холбоотой заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2.Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн 121.4 сая төгрөгийн 27 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.2 дахь заалт, Аймгийн ИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 3.3.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Хөрөнгийн ашиглалт, чанар байдалд тавих хяналт алдагдах, үнэлгээ, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн хөрөнгүүдийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж, удирдлагад санал дүгнэлт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.16	Аудитын нэр: Сайншанд сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/74/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Сайншанд сумын ИТХ	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийн төлөвлөлт	0	Зөвлөмж өгсөн	ИТХ-ын төлөөлөгчид	
2	Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн хөрөнгө	0	Зөвлөмж өгсөн	Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Х.Хоролсүрэн
3	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгө	6500.0	Албан шаардлага	Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Х.Хоролсүрэн
ДҮН		6500.0			